

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо: 2021.4.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/3/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Үндсэн хуулийн цэц
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Аудитор Б.Долгоржав

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн					Аудит хийгээгүй
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	ТЕЗ	1	1				1			
	ДҮН	1	1	1			1			

Гурав. Аудитын үр дүн

3.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
A	1	2	3	4	5	6	7
1	ТЕЗ	4	76.4	0.0	0.0	76.4	
	ДҮН	4	76.4	0.0	0.0	76.4	

3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

Алдаа, зөрчилтэй асуудал 1.

Батлагдсан төсвийн урсгал засварын зардлаас 2.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 23.6 сая, мэдээлэл технологийн зардлаас 1.8

сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 48.6 сая төгрөг нийт 76.4 сая төгрөгийг төсвийн ангилал зөрчин зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах, тогтоосон ангиллын дагуу зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Алдаа, зөрчилтэй асуудал 2.

Кассаар нийт 61.6 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэнээс харилцах дансаар хийх бололцоотой 43.2 сая төгрөгийн 71 ажил гүйлгээ байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэсэн заалт, "Мөнгөн кассын ажиллагааны журам"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлэн мөнгөний зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, "Мөнгөн кассын ажиллагааны журам"-ын холбогдох заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

Алдаа, зөрчилтэй асуудал 2.

Төсвийн зохицуулалт хийх Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр 14.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 14.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, 11.7 сая төгрөгийн программ хангамжийг урсгал зардлаас бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах талаар зөвлөмж өгсөн.

Алдаа, зөрчилтэй асуудал 3.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тендерт шалгарсан компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах шийдвэргүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т "Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ", 49.2.8-д "гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдлийг хангах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.8 дахь заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ДАРГА Н.ЧИНБАТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1319
танай _____-ны № _____-т
Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A square red stamp containing a handwritten signature in cursive script. The signature appears to be "Д. ЗАНДАНБАТ".

Д.ЗАНДАНБАТ